



**МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН
БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБОО**

**МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН
БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ
ТӨЛӨВЛӨГӨӨ / 2012-2016 /**

2011 оны 12 дугаар сарын 8

МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙН

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ / 2012-2016 /

Нэг. Монголын банк бус санхүүгийн байгууллагын хөгжлийн өнөөгийн төлөв байдлын шинжилгээ, үнэлгээ

Хоёр. Монголын банк бус санхүүгийн байгууллагыг 2012 - 2016 он хүртэлх хугацааны хөгжлийн стратеги төлөвлөгөө

- ✓ Зорилго 1. ББСБ-ын активын өсөлтийг хангах
- ✓ Зорилго 2. Сургалт, боловсон хүчнийг чадваржуулах
- ✓ Зорилго 3. Санхүүгийн тогтвортой байдлыг хангаж сайжруулах
- ✓ Зорилго 4. Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ бий болгох түүний эрх зүйн орчныг бүрдүүлэх
- ✓ Зорилго 5. Нийгмийн хариуцлага
- ✓ Зорилго 6. Зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлэх
- ✓ Зорилго 7. Эрх зүйн орчныг сайжруулах
- ✓ Зорилго 8. Төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах
- ✓ Зорилго 9. МББСБХ-г бэхжүүлэх, хөгжүүлэх

Гурав. Монголын банк бус санхүүгийн байгууллагын холбооны 2012 оны үйл ажиллагааны төлөвлөгөө

Нэг. Монголын банк бус санхүүгийн байгууллагын дотоод орчны шинжилгээ

Монголын банк бус санхүүгийн байгууллагын дотоод орчны шинжилгээ: Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны орчны эерэг болоод сөрөг хүчин зүйлүүд, давуу болоод сул талуудыг SWOT шинжилгээний аргаар тодорхойлов.

Давуу тал /Strengths/	Сул тал /Weaknesses/
<ul style="list-style-type: none"> • Банкны шалгуур хангаж чадахгүй бичил бизнес эрхлэгчдийг дэмжих бодлого сайн • Шуурхай үйлчилгээ • Богино хугацааны санхүүгийн хэрэгцээг хангах чадвар • Нийт активын 70 орчим хувийг өөрийн хөрөнгө эзлэж байгаа нь эрсдэл даах чадвар өндөр • ББСБ-ын үйл ажиллагааны тухай хууль батлагдаад 9 жил болж байгаа учир энэ салбарын үйл ажиллагаа харьцангуй жигдэрсэн • Харьцангуй бага зардлаар түргэн шуурхай үйлчилгээ үзүүлж байгаа • Банк санхүүгийн салбарын өөрийн хөрөнгийн 20 гаруй хувийг эзэлдэг • Салбартаа голлох байр суурьтай ББСБ-уудын удирдлагууд ур чадвартай, мэргэжилийн түвшиний олон жилийн туршлагатай • Ажилтнууд мэргэжлийн дадлага туршлага эзэмшсэн • ББСБ нь цомхон бүтэцтэй байдаг тул шийдвэр гаргалт хурдан, үйл ажиллаганд хяналт тавихад хялбар • Зээлийн багцын чанар сайн, гүйцэтгэл сайн гэдэг нь хямралын үед батлагдсан • Шуурхай харилцагч бүрийн хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ • Бичил ба жижиг зээлийн үйлчилгээний хувьд банктай харьцуулхад илүү мэдрэмж, туршлагатай • Холбоо нь СЗХ болон МҮХАҮТ хамтран ажиллаж байгаа • Холбооны нэрэмжит шагналтай • Удирдах зөвлөл цаг хугацаагаа холбооны хөгжилд зориулж чаддаг 	<ul style="list-style-type: none"> • Салбарын эрх зүйн орчин хангалтгүй, тодорхой бус, /иргэний хууль, үндсэн хууль ББСБ-ын тухай хууль СЗХ-ны журмууд, ШШГЕГ, ЭХЭУБГ/ • Төрийн байгууллагын зүгээс салбарт үзүүлэх дэмжлэг сул • ББСБ-ын талаарх иргэд, ААНБ-уудын ойлголт сөрөг • Зээлийн дундаж хүү өндөр • ББСБ-ын тухай хуулинд заасан зээлийн үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагааг эрхлэх биднесийн болон эрх зүйн таатай орчин бүрдээгүй • Бусдаас эх үүсвэр татан төвлөрүүлэхэд тавигдах эрх зүйн хязгаарлалт чанга, өндөр • Голлон өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаагаа явуулж байгаа учир санхүүгийн үр ашиг буурч байгаа • Гадны эх үүсвэр татаж хөшүүргийг нэмэгдүүлэх боломжийг СЗХ-с хязгаарлаж байгаа • Банк санхүүгийн салбарын өөрийн хөрөнгийн 20 гаруй хувийг эзлэж байгаа ч нийт активын 2 орчим хувийг эзлэж байна. Цаашид улам бүр буурах хандлагатай. • Харьцангуй бага зах зээлд олон жижиг ББСБ-ууд үйл ажиллагаагаа явуулжбайгаа • Мэдээлэлийн технологийн ололт амжилтыг үйл ажиллагаандаа бага нэвтрүүлсэн • Зээлийн мэдээлэлийн сантай харьцах харьцаа муу • Боловсон хүчин болоод үйл ажиллагаандаа шаардагдах үйлчилгээний стандартыг сул мөрддөг / тухайлбал ченж ББСБ/ • Салбарын нэр хүнд тааруу нийгмийн ихэнх хэсэг ХЗХ-с ялгаж ойлгодоггүй • Боловсон хүчний сургалт дутагдалтай • Сургалтын төсөвгүй, төлөвлөгөөгүй, материаллаг баазгүй • Боловсон хүчнийг мэргэшүүлэх, чадваржуулах сургалтгүй • ББСБ-ын засаглал, нээлттэй ил тод байдал сул • ББСБХолбооны үйл ажиллагааг идэвхжүүлэхэд санхүүгийн эх үүсвэр дутагдалтай • Томоохон ББСБ Холбоондоо нэгдсэн ч ихэнх ББСБ-ууд нь нэгдэж ажиллаж чаддаггүй • Өнөөгийн хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох зайлшгүй шаардлага байгаа • Санхүүгийн боломж хязгаарлагдмал эх үүсвэрийн өртөг өндөр • Гадаад санхүүжилт төсөлд хамрагдахад актив хөрөнгийн хэмжээнээс хамааран шаардлага хангадаггүй • Цөөн эх үүсвэрээс санхүүжилт авч, өөрийн хөрөнгөөр бага эргэлтээр бизнесээ явуулдаг

	<ul style="list-style-type: none"> • Өртөг өндөртэй, бага хэмжээний өөрийн эх үүсвэрт түшиглэх үйл ажиллагаагаа явуулдаг тул үйл ажиллагаагаа өргөжүүлэх, харилцагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдхүүн үйлчилгээг гаргах харилцагчаа хадгалан үлдэх хэцүү • СЗХ-с ББСБ-г хөгжүүлэх дэмжлэг үзүүлж чаддаггүй, хяналт ихтэй • МББСБХолбоо гишүүнчлэлийн тоо цөөн учир салбарын нэгдсэн эрх ашиг хамгаалах боломж бага • Холбооны орон тооны ажилтангүй, байргүй • Салбар нэгжийн тоо цөөн учир зах зээлд хүрч ажиллах боломж муу • Зээлийн хүү өндөр • Холбооны ач холбогдол ББСБ-д хангалтгүй байна. • Олон улсад хэрэгжиж байгаа санхүүгийн үйлчилгээний мэдлэг бага • Гадаад харилцаа муу хөгжөөгүй • Иргэд ББСБ болон ХЗХ ны ялгааг сайн мэддэггүй • Нийгэмд салбарын нэр хүнд муу, ойлголт тааруу, тиймээс ч төрийн зүгээс явуулж буй төсөл хөтөлбөрт хамрагдаж чаддаггүй. • СЗХ төрийн байгууллагуудтай ББСБ-уудад санхүүжилт олгох талаар санаачлагатай ажиллаж чаддаггүй / тухайлбал ЖДҮГ-ын зээлийг ББСБ-аар дамжуулж олгодоггүй /
<p>Боломж /Opportunities/</p> <ul style="list-style-type: none"> • Өрхийн бичил бизнес, жижиг дунд үйлдвэрлэгчдийн бизнесийг бодитоор дэмжиж ажлын байр нэмэгдүүлэх, амьжиргааны түвшинг дээшлүүлэх зэргээр нийгэм эдийн засагт оруулах хувь нэмэр өндөр • Санхүүгийн зах зээлийн хүнд сурталыг арилгах • Бичил зээлийн үйлчилгээг илүү хүртээмжтэй болгох • Шинэ бүтээгдхүүн үйлчилгээ нэвтрүүлэх замаар салбарын үйл ажиллагааг өргөжүүлэх • Нэмэлт эх үүсвэр татах /гадна дотроос/, өөрийн хөрөнгө их тул • Бага зардал цомхон бүтцээр хямд бүтээгдхүүн үйлчилгээг үйлчлүүлэгчдэд хүргэх замаар зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлэх • Өөрсдийн амжилт бүтээлийг олон нийтэд таниулан сурталчилах замаар нийгэмд эзлэх байр сууриа нэмэгдүүлэх • ББСБХолбоогоор үйл ажиллагааг идэвхжүүлэх замаар төрийн байгууллын зарим чиг үүргийг уг холбоогоор дамжуулан гүйцэтгүүлэх • Нийгэмд салбарын талаар зөв эерэг мэдээлэл хүргэж улмаар төр, бусад байгууллагатай нягт хамтран ажиллаж нийгэмд чиглэсэн олон ажлыг зохион байгуулах боломжтой. • СЗХ-той хамтран ажиллах замаар шалгуур үзүүлэлтүүдийг зөөлрүүлэх, эх үүсвэр татах боломжийг нэмэгдүүлэх • Боловсон хүчнээ тогтмол сургалтуудад хамруулж чадавхийг нь нэмэгдүүлэх 	<p>Аюул занал /Threats/</p> <ul style="list-style-type: none"> • Нийт санхүүгийн зах зээлд эзлэх хувь маш бага учир зах зээлээ алдах магадлал өндөр • Жижиг зах зээлд хэт олон ББСБ, ХЗХ банкууд үйл ажиллагаа явуулж байгаа учир нэг хэсэг нь зах зээлээс шахагдан дампуурах аюул байгаа • Өрсөлдөгчдөд ижил боломж олгох шаардлагатай, тухайлбал эх үүсвэр татах боломж өөр өөр байгаа хязгаарлалт, зохицуулалтын хөлс хураамж авах зэрэг нь банктай харьцуулхад илүү дарамттай байдаг • Банкны тухай хууль шинэчлэгдэж ББСБ-ын ихэнх үйл ажиллагааг банкууд эрхлэж эхэлсэн нь зайлшгүй аюулыг бий болгож байна. Цаашид ч Банк, ББСБ –ын үйл ажиллагааны ялгаа арилах нь ББСБ зах зээлээс шахагдах аюултай. • Зээлийн эрсдэлийг бууруулах чанаргүй зээлийг барагдуулах, хууль эрх зүйн орчинг сайжруулах шаардлага байгаа • Эх үүсвэр хомс байдлаас шалтгаалан найдвартай харилцагчаа банкинд алдах • Арилжааны банкны үйл ажиллагааны идэвхжилт, лобби • ББСБ-ын эрхлэх үйл ажиллагааны тоог цөөлөх хандлага бодитоор бий болсон • Банктай өрсөлдөх чадвар хэт доогуур зах зээлээс шахагдах хандлага үүссэн • Төрийн байгууллагууд, сангаас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрт ББСБ оролцох эрхийг хязгаарлаж эхэлсэн

<ul style="list-style-type: none">• ЖДҮ-ийг хөгжүүлэх эх үүсвэрийг ББСБ-уудаар дамжуулан олгох асуудлыг тавьж шийдвэрлүүлэх• Хууль эрх зүйн орчин бэхжиж эхэлсэн• Бага дунд орлоготой иргэд, жижиг бизнес эрхлэгчидэд санхүүгийн үйлчилгээг түргэн шуурхай хүртээмжтэй хүргэдэг• ББСБ-уудын үйл ажиллагаа идэвхтэй өрсөлдөөн хүчтэй• СЗХ болон МББСБХ хамтын ажиллагааг сайжруулах, хамтран салбарын хөгжлийг шинэ шатанд гаргах• МББСБХолбооны гадаад харилцааг хөгжүүлэх болон төрийн болон бусад байгууллгатай хамтын ажиллагааг сайжруулан төсөл хөтөлбөрт хамрагдах• Шинэ бүтээгдхүүн үйлчилгээ тухайлбал санхүүгийн түрээс, IPO гэх мэт нэвтрүүлэх эрхтэй болсноор нийт актив, өөрийн хөрөнгө ба ашигт ажиллагаагаа нэмэгдүүлэх• Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ явуулж байгаа хувь хүн, албан байгууллагыг СЗХ-той хамтран зохицуулалт хийх цаашид зах зээлээс шахах тэдгээрийн харилцагчдыг татах• Олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах бүрэн боломжтой	
--	--

**Хоёр. Монголын банк бус санхүүгийн байгууллагыг 2012 - 2016 он хүртэлх
хугацааны хөгжлийн стратеги төлөвлөгөө**

Зорилго 1. ББСБ-ын активын өсөлтийг хангах:

SWOT шинжилгээгээр ББСБ-уудын нийт активын өсөлт бага, өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаагаа явуулж байгаа, бусдын хөрөнгө дайчлах чадвар муу гэж сул талд гарсан байна. / ББСБ-уудын өөрийн хөрөнгө нь нийт Банк санхүүгийн салбарын өөрийн хөрөнгийн 21 хувийг эзлэж байгаа хэдий ч нийт активийн 2 орчим хувийг эзлэж байгаа / Иймд активын өсөлтийг хангах зайлшгүй шаардлагатай байна.

Зорилтууд	Хэрэгжүүлэх арга замууд	Үндэслэл, тайлбар	Хэрэгжүүлэх субъект	Хэзээ
Зохистой харьцааны үзүүлэлтүүдийг сайжруулах	СЗХ-ны ББСБ-ын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлийг тооцож хяналт тавих журмын 3.5 заалтын 8 хувиас доошгүй байна гэдгийг 5 хувиас доошгүй байна гэж өөрчлөх.	Ижил төсөөтэй банкны салбартай ижил түвшинд тавих. Хэрэв өөрчлөхгүй бол эх үүсвэрийн зардал өсч зээлийн хүү өндөр өрсөлдөх чадварыг сулруулдаг.	СЗХ МББСБХ	2012
Зохистой харьцааны үзүүлэлтүүдийг сайжруулах	Дээрх журмын 4.5 . . . гаргасан хувьцааны нийт дүнгийн 10 хувиас дээшгүй байна гэдгийг 34 хувиас гэж өөрчлөх.	Хяналтын багцыг авах боломжийг бүрдүүлэх шаардлагатай.	СЗХ МББСБХ	2012
	Дээрх журмын 6.2 ыг хувьцаат капитал гэдгийг өөрийн хөрөнгийн гэж өөрчлөх, улмаар нийт активын 60 хүртэл хувь болгох	Бусдын хөрөнгийг дайчлах чадварыг тухайн ББСБ-ын ажилласан жил үр дүнг харгалзан дээшлүүлэх шаардлагатай байна. Нийт активын 60 хувь гэдэг нь Монгол банканд хяналт байх үетэй ижил түвшинд буцаан тавих	СЗХ МББСБХ	2012-онд өөрийн хөрөнгө улмаар активтай 2013 онд
	Дээрх журмын 7.2-ыг 15 хувиас гэдгийг 25 хувь болгох	Өнөөгийн зохицуулалт нь түрээсийн байранд байх нөхцлийг бүрдүүлж байгаа болно. Иймд өөрийн байртай болоход энэхүү харьцааг өөрчлөх шаардлагатай байна.	СЗХ МББСБХ	2012
Өрийн бичгийн харьцааг сайжруулах	Өрийн бичиг гаргах журмын 2.7-г хасах	Өрийн бичгийг өөрийн хөрөнгийн 50 хувь хүртэл гаргах тухай заалт байхад дахин итгэлцлийн үйлчилгээтэй бол гэж хязгаарлалт заах шаардлагагүй.	СЗХ МББСБХ	2012
Хадгаламж	-Одоо хэлэлцэгдэх гэж байгаа Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчлэсэн найруулгад оруулан шийдвэрлэх	Дэлхийн бусад ижил төсөөтэй санхүүгийн байгууллагууд хадгаламж авдаг туршлага их бий. Санхүүжилт татах гол арга юм. Харин дүрмийн сан бусад шалгуурыг өндөр хатуу тавьж өгөх	СЗХ, ББСБХолбоо УИХ	2013
Гадаад, дотоодын төсөл хөтөлбөрт хамрагдах	ЖДҮГ-ын зээлийг дамжуулан зээлдүүлэх үйлчилгээ, орон сууцны урт хугацаат моргежийн дамжуулах зээл, гэх мэт төрийн болон гадаадын төслүүдэд оролцдог болох	ЗГ-с хэрэгжүүлж буй ажлын байрыг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах, чинээлэг иргэдийн давхаргыг ихэсгэх үндсэн зорилгыг ББСБ-уудаар	СЗХ тэргүүлэн МББСБХ идэвхтэй санаачлагатай	2012-2016

		дамжуулан хэрэгжүүлвэл жинхэнэ биедэх болно.Жижиг дунд үйлдвэрийн газрын зээл гэхэд 5-8 тэрбумыг хэдхэн газруудад өгч байгаа нь жижиг дунд үйлдвэрлэл гэж үзэхэд асуудалтай гэж үзэж байна.	ажиллах шаардлагатай байна	
Нэр хүнд бүхий аудитын компаниар аудит хийлгэдэг болох	Гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээсэн аудитын компаниудаар аудит хийлгэх	ББСБ-уудын удирдлагуудад гадаад аудитын үйл ажиллагааг нэр төдий хийлгэдэг бус үр ашиг тусыг зөвөөр ойлгуулах шаардлагатай байна.	МББСБХ уриалан ББСБ-ууд	2012-2016
Рейтинг тогтоох	СЗХ, МББСБХ хамтран эхний ээлжинд зэрэглэл тогтоодог болох, улмаар гадаадын нэр хүнд бүхий рейтингийн компаниар үйлчилгээг хийлгэдэг болгох	Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг мэдээллээр хангах, шийдвэр гаргахад нь туслах, ББСБ-ууд өөрсдийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ өгч хөгжүүлэх үндсэн арга юм.	СЗХ, МББСБХ ББСБ-ууд	2012-2016
Гадаад харилцааг хөгжүүлэх	СЗХ, МББСБХ дэргэдээ гадаад харилцаа хамтын ажиллагааны ажилтануудтай болж төлөвлөгөө төсөвтэйгөөр нягт хамтран идэвх санаачлагатай ажиллах	Дэлхийн хөгжилтэй мөр зэрэгцэх, мэдээлэл солилцох, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх, зөвлөгөө сургалт авах, дэвшилтэд техник технологи нэвтрүүлэх, бусад хамтын ажиллагаа	СЗХ МББСБХ ББСБ-ууд	2012-2016

Зорилго 2. Сургалт, боловсон хүчнийг чадваржуулах:

Боловсон хүчний сургалт дутагдалтай, сургалтын тусгай хөтөлбөр, материаллаг баазгүй, төсөвгүй боловсон хүчнийг мэргэшүүлэх, чадваржуулах сургалтгүй, мэдээллийн технологийн ололт амжилтыг үйл ажиллагаандаа бага нэвтрүүлсэн, зээлийн мэдээллийн сантай харьцах харилцаа муу, боловсон хүчин болон үйл ажиллагаандаа тавих шаардлага, стандарт сул гэж SWOT шинжилгээний сул талд гарсан байна.

Зорилтууд	Хэрэгжүүлэх арга замууд	Үндэслэл, тайлбар	Хэрэгжүүлэх субъект	Хэзээ
Нэгдсэн сургалт хариуцсан эзэнтэй болгох	Сургалтыг МББСБХ-нд шилжүүлэх, СЗХ-ноос төсвийг шийдвэрлэж өгөх	Дэлхийн жишгээр төрийн бус байгууллагад зарим нэг төрийн чиг үүргийг шилжүүлэх тухай төр засгаас ихээхэн ярьж зарим нэг алхамууд хийгдэж байна. Бидний эхний алхамуудын нэгийг энэ зорилт гэж үзэж байна.	СЗХ, МББСБХ	2012 оноос
Гадаад сургалт, семинарт ББСБ-уудыг түлхүү хамруулах	Гадаад харилцааг өргөжүүлэх, тусламж дэмжлэг авах, дотоод нөөц бололцоог дайчлах /MDF 2010 онд 10 ББСБ-уудын зардлын 50 хувийг даасан/ ББСБ-уудын удирдлагуудад ач холбогдлыг ойлгуулах	Хөгжлийн нэг чухал арга зам юм.	СЗХ, МББСБХ	2012-2016
Гаднаас сургалт авч эх орондоо явуулах	Гадаад харилцааг өргөжүүлэх замаар		СЗХ, МББСБХ	2012-2016
Холбооны сертификаттай сургалтыг бий болгох	Сургалтын төсөв, сургалтын багтай болсоноор стандарт сургалтуудыг бий болгоно. Мөн байгууллагын сайн засаглал, удирдлага, стратегийн сургалтуудтай болох	Теллер, Эдийн засагч, Нябо, Дотоод аудитор, Салбарын захиралын гэсэн сургалтууд стандарттай болно. Мөн мэргэшүүлэх, ахисан түвшинь сургалтуудтай болно.	СЗХ, МББСБХ	2012-2016
Мэдээлэл, технологийн дэвшилтэд ололтыг нэвтрүүлэх	Зээлийн мэдээллийн санд 100 хувь хамрагдах, Шилдэг программ хангамжаар ажиллах, сургалт явуулах	Мэдээллийн санд муу харилцаж байгаа нь нэгд программ хангамжгүй, төсөв зардал гаргадаггүй, нээлттэй ил тод байхыг хүсдэггүй, программаа хэрэглэж чаддаггүй, мэддэггүй зэргээс шалтгаалдаг байна.	СЗХ, МББСБХ	2012-2016

Зорилго 3. Санхүүгийн тогтвортой байдлыг хангаж сайжруулах:

Цөөн эх үүсвэрээс санхүүжилт авч, өөрийн хөрөнгөөр бага эргэлттэй явж байгаа нь цөөн харилцагч зээлдэгч, эх үүсвэр найдваргүй байдлыг бий болгож өнөөгийн сул тал болж байна. Харин энэхүү стратеги төлөвлөгөө хэрэгжсэнээр санхүүжилт татах эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийг бий болгосноор хяналт шалгалт, дотоод гадаад аудитын үйл ажиллагааг шинэ шатанд гаргах шаардлага урган гарна.

Зорилтууд	Хэрэгжүүлэх арга замууд	Үндэслэл, тайлбар	Хэрэгжүүлэх субъект	Хэзээ
Аудитын үйл ажиллагааг шинэ шатанд гаргах	ББСБ бүрийг жинхэнэ утгаар нь дотоод болон гадаад аудитын үйл ажиллагаатай болгох	Компаний сайн засаглалын нэгэн чухал хэсэг болох Хяналтын зөвлөл, дотоод аудитор, гадаад хөндлөнгийн аудитын үйл ажиллагааг хэвшүүлэх, улмаар нээлттэй ил тод байдалтай болгох	СЗХ, МББСБХ	2012 оноос
Ажлын байрны болон боловсон хүчний, үйлчилгээний стандарт бий болгох	СЗХ, МББСБХ нь дээрх 3-н стандартыг шинэчлэн бий болгож хянаж хэвшүүлэх, шинээр бий болох ББСБ-д тавигдах шаардлагад оруулах	Дээрх 3-н стандарт нь нийт салбарын нэр хүндэд хамааралтай байгаа ба шинэ шатанд гаргах шаардлагатай гэж үзэж байна. Подвальд амны хаалттай, энгийн хувцастай, ямар нэг бизнесийн ёс зүйгүй, харилцаа муутай үйл ажиллагаа явуулж байгаа ББСБ цөөнгүй байна.	СЗХ МББСБХ	2012
Хяналт шалгалтын сайжруулах	Заавал газар дээр бус аль болох зайны боловсронгуй, оновчтой хяналт шалгалтыг бий болгох	Ажлын байранд төрийн албан тушаалтан байнга шалгах нь олон хүндрэлүүдийг бий болгодог. Иймд мэдээлэл солилцоо, тайлагналыг боловсронгуй, оновчтой болгох зайлшгүй шаардлагатай үед л газар дээрх шалгалтыг хийж байх. ХЗ, Дотоод болон гадаад аудитын үйл ажиллагааг ашиглах	СЗХ МББСБХ	2012-2016
Зохистой харьцааг хангаж ажиллах	Үйл ажиллагаанд илт чөдөр тушаа болсон харьцааг арилгаж, зохистой харьцааг хатуу барьж ажиллах		СЗХ	2012-2016

Зорилго 4. Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ бий болгох түүний эрх зүйн орчныг бүрдүүлэх:

Зорилтууд	Хэрэгжүүлэх арга замууд	Үндэслэл, тайлбар	Хэрэгжүүлэх субъект	Хэзээ
Хадгаламж	Одоо хэлэлцэгдэх гэж байгаа Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчлэсэн найруулгад оруулан шийдвэрлэх /хэрэгжиж эхлэх хугацааг 2013 оноос гэж тавьж болно/	СЗХ, ББСБХолбооноос УИХ-тай хамтран шийдвэрлүүлэх	2013 онд багтаан шийдвэрлэх	Хадгаламж
Санхүүгийн түрээс	Одоо хэлэлцэгдэх гэж байгаа Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчлэсэн найруулгад оруулан шийдвэрлэх /Хуучин хууль дээр байсан хэдий ч Санхүүгийн түрээсийг тусгай зөвшөөрөлгүйгээр эрхлэх тухай хууль гарсантай холбогдуулан энэ заалтыг хүчингүй болгосныг сэргээж оруулах.	СЗХ, ББСБХолбооноос УИХ-тай хамтран шийдвэрлүүлэх	2013 онд багтаан шийдвэрлэх	Санхүүгийн түрээс
IPO /хувьцааг нийтэд арилжаалах/	Аливаа бизнесийн байгууллагын хөгжлийн дараагийн шат болох IPO-г хийх боломжуудыг ББСБ-уудад олгож улмаар ББСБ-уудын санхүүгийн чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх	СЗХ, МББСБХолбоо	2012 онд багтаан шийдвэрлэх	IPO /хувьцааг нийтэд арилжаалах/
Итгэлцэл	Итгэлцлийн үйлчилгээнд тавьж байгаа хязгаарлалтуудыг зөөлрүүлэх, дүрмийн сангийн 80 хувь гэсэн хязгаарлалтыг өөрийн хөрөнгийн 80 хувь болгох, цаашлаад улам зөөлрүүлж активтай уяж өгөх /өмнө нь активтай уядаг байсан зарчмаар/ -Итгэлцлийн үйлчилгээг улам боловсронгуй болгох	-СЗХ, ББСБХолбоо	2012 онд багтаан шийдвэрлэх	Итгэлцэл
Өрийн бичиг	Өрийн бичгийн журмыг эргэн харж амьдралд хэрэгжих боломжийг нэмэгдүүлэх, тухайлбал нэгэнт хэвийн үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагад зөвшөөрөл өгөхийн тулд дахин шалгалт оруулдаг байдал, итгэлцэл, өрийн бичгийн нийлбэр дүн нь өөрийн хөрөнгийн 80 хувь гэдэг хязгаарлалтыг сулруулж нийт активтай уяж өгөх, мөн нэгэнт СЗХ зөвшөөрөл олгосныхоо төлөө хариуцлага хүлээхгүй гэж заасан учраас зөвшөөрлийг аль болох хүнд сурталгүй олгодог болгох, цаашлаад тухай бүрт зөвшөөрөл олгодог бус бүртгэдэг зарчим руу шилжих	-СЗХ, МББСБХолбоо	2012 онд багтаан шийдвэрлэх	
Хөрөнгө итгэмжлэх	Олон улсын стандартын дагуу хөрөнгө итгэмжлэх үйлчилгээг бий болгож хөхүүлэн дэмжих	-СЗХ, МББСБХ	2013 онд багтаан шийдвэрлэх	
Цахим мөнгөний үйлчилгээнд суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээ	Одоогоор ганц нэг ББСБ-ууд нэвтрүүлж эхлээд байгаа боловч гүйлгээнд тавьж байгаа хязгаарлалтууд нь уг бүтээгдэхүүний амьдралд хэрэгжих нөхцөлийг бууруулж байгааг эргэн харах	-СЗХ, МББСБХ	2012 онд багтаан шийдвэрлэх	

Жич: Аливаа байгууллага нь зар сурталчилгаагаар дамжуулан шинэ бүтээгдэхүүн үйлчилгээгээ олон нийтэд хүргэдэг учраас энэ зарчмыг харгалзан зар сурталчилгаанууд дээр тавьдаг хоригуудаа эргэж харах.

Зорилго 5. Нийгмийн хариуцлага:

Олон улсын стандартчиллын байгууллагаас нийгмийн хариуцлагын ISO 26000 стандартыг боловсруулан 2010 онд баталгаажуулсан билээ. Үүнд:

- ❖ Өөрийн байгууллагын үйл ажиллагаа, гаргасан шийдвэрийн нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөний талаар бүрэн хариуцлага хүлээх;
- ❖ Нийгмийн сайн сайхан, тогтвортой хөгжлийг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ил тод нээлттэй явуулах;
- ❖ Бизнесийн ёс зүйг эрхэмлэн дээдлэх;
- ❖ Бизнес хамааралтай оролцогч талуудын хүлээлт, ашиг сонирхлыг эхний ээлжинд тавих;
- ❖ Хууль болон Олон улсын бизнесийн норм, хэм хэмжээг эрхэмлэн сахих;
- ❖ Байгууллагынхаа үйл ажиллагааг гадаад орчинтой нягт уялдуулан зохицуулах явдал юм.

МББСБХ-ны 2012-2016 оны нийгмийн хариуцлагад хүлээж буй зорилго нь нийгмийн сайн сайханд бодитойгоор хувь нэмэр оруулах, шинэлэг үйлчилгээг нэвтрүүлж ард иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, жижиг дунд үйлдвэрлэл, төслийг дэмжих, тухайн орон нутгийн хөгжил цэцэглэлтэд хувь нэмэр оруулах зорилготойгоор үйл ажиллагаа явуулах нь зөв зохистой алхам юм.

Зорилтууд	Хэрэгжүүлэх арга замууд	Үндэслэл, тайлбар	Хэрэгжүүлэх субъект	Хугацаа	
Улс орны өмнө хүлээх хариуцлага	Нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах үүднээс бичил санхүүгийн үйл ажиллагааг дэмжих	Төр засгаас хэрэгжүүлж буй хууль тогтоомжид бичил санхүүгийн байгууллагуудын эрх ашгийг хамгаалсан дуу хоолойг нэгтгэн хүргэх	Санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг СЗХ-с хэт өндөр шалгуур тавьдаг	СЗХ, МББСБХ	2012-2016
	Олон улсын бичил санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах	Олон улсын жишигт нийцсэн үйл ажиллагаа явуулж, дэлхийн бичил санхүүгийн холбооны гишүүн	Дэлхийн зээлийн стандартыг улс орныхоо нөхцөл байдалд нийцүүлэн сайжруулж авч хэрэглэх	СЗХ, МББСБХ	2012-2016
	Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг тогтвортой хөгжүүлэх	ББСБ-ын үйл ажиллагаа нь улс орны аюулгүй байдалд нийцсэн үр өгөөжтэй үйл ажиллагаа байх	Нийгэмд инфляц тогтворгүй байгааг зөвөөр тусган үйл ажиллагаандаа авч хэрэгжүүлэх	МББСБ	2012-2016
	Жижиг дунд үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт хийх тал дээр төр засгаас дэмжлэг авах	- Төсөл - ББСБ-н хуулийг боловсронгуй болгох	Төслийн хөрөнгө оруулалтанд төр засгаас дэмжлэг авч чаддаггүй	МББСБХ	2012-2016

Нийгэм олон нийтийн өмнө хүлээх хариуцлага	Нийгмийн ядуурлыг бууруулах хүрээнд шинэ ажлын байрыг бий болгох	Жижиг хүртээмжтэй ажлын байр шинээр бий болгох	Монголын нийгэмд ажилгүйчүүдийн тоо их байгаагаас ядуурал ихсэж байна	МББСБХ	2012-2016
	Нийгэмд хүмүүнлэгийн үйл ажиллагааг тогтмол зохион явуулж байх	Байгаль орчин, соёлын үйл ажиллагаа: тухайлбал эмзэг бүлгийн хүүхдэд, эмнэлэгийн туслалцаа авч чадахгүй байгаа хүмүүст санхүүгийн болоод хүмүүнлэгийн аянг явуулах	Монголын хүүхэд багачууд болон эмзэг бүлгийн хүүхэд, хорт хавдар болон аюулт өвчинд шаналж буй иргэдэд ард олныг уриалсан хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулах	МББСБХ	Улиралд 1 удаа
	ББСБ-ын үйл ажиллагааг нийгэмд зөвөөр таниулах, зөв ойлголтыг бий болгох ажлын хүрээнд	Соёл хүмүүжил, урлагийн Сургалт сурталчилгааны ажлын хүрээнд явуулах	ББСБ-ыг ХЗХ-ны үйл ажиллагаанаас ялгуулан таниулах Банкны үйл ажиллагаанаас ББСБ-н үйлчилгээний давуу талыг таниулах	МББСБХ	2012-2016
Үйлчлүүлэгч болон харилцагчдийн өмнө хүлээх хариуцлага	Харилцагч, үйлчлүүлэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээ явуулах	Шинэ шуурхай соёлч үйлчилгээг нэвтрүүлэх	Олон төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлж хэрэглэгчдийн эрх ашигт нийцсэн байх	МББСБ	2012-2016
	Хэрэглэгчдэд ойртсон үйлчилгээг үзүүлж, дэлхийн жишигт нийцсэн шинэлэг технологийг нэвтрүүлэх	ОУ-ын туршлага судлах	Олон улсын жишигт нийцсэн шинэлэг техник технологээр дутагдаж байдаг.	ББСБ	2013-оос
	Зээлийн үйлчилгээг хялбар дөхөм болгох үүднээс нэг цэгийн үйлчилгээ үзүүлдэг болох	Холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж шаардлагатай мэдээллийг цаг алдалгүй хүлээн авч хүртээмжтэй болгох	Зээлдэгч үйлчлүүлэгчид зээлийн үйлчилгээ авахад хэт удаан хугацаа шаардах явдал элбэг байдаг	МББСБХ	2012-2016
ажилгасдагчдын өмнө хүлээх хариуцлага	Боловсон хүчний мэдлэг боловсролыг дээшлүүлж сургалт сурталчилгаанд хамруулах	Сургалтанд хамруулах, сурах орчинг бүрдүүлж өгөх	Баялаг их, мэдлэг бага байх нь ашгийг нэмэгдүүлэх бус бууруулах эрсдэлтэй тул чадварлаг боловсон хүчинг бэлтгэх	СЗХ	2012-2016

Ажилтан албан хаагчдийн нөхцөл бололцоог хангах үүднээс нийгмийн асуудалд анхаарал хандуулаж бололцоотой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх	Жил бүрийн бизнес төлөвлөгөөнд тусгах замаар хэрэгжүүлнэ	Авливаа байгуулагыг хөдөлгөгч хүч нь ажилтан албан хаагчид байдаг тул нийгмийн асуудалд анхаарал хандуулах нь чухал хүчин зүйл	ББСБ	2012-2016
Ажилчдийн дунд бие бялдар эрүүл ахуйг хөгжүүлэх аянг зохион явуулах	Спорт урлагийн арга хэмжээг нэгдсэн зохион байгуулалттайгаар авч хэрэгжүүлэх	Эрүүл биед саруул ухаан оршино.	МББСБХ	Улиралд 2-3 удаа

Зорилго 6. Зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлэх:

Зорилтууд	Хэрэгжүүлэх арга замууд	Үндэслэл, тайлбар	Хэрэгжүүлэх субъект	Хэзээ
ББС-ын үйл ажиллагааны тухай хуулинд заагдсан ББСБ-ын эрхэлж болох үйл ажиллагаа тус бүрээр зах зээлийн өнөөгийн байдал болон ирээдүйн хандлагын талаар нарийвчилсан судалгаа хийх	Судалгааны мэргэшсэн байгууллагаар захиалж хийлгэх эсвэл хамтарч хийх	ББСБ-уудад зах зээлийнхээ боломжийг бүрэн ашиглаж үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд нь судалгаа, тусламж шаардлагатай байна.	МББСБХ СЗХ Судалгааны мэргэшсэн байгууллагатай хамтран	2012 оны 1-р улиралд
Хуулинд заагдаагүй хэдий ч бусад орны ББСБ-уудын эрхэлдэг үйлчилгээнүүд, манай зах зээлийн талаар судалгаа хийх	Судалгааны мэргэшсэн байгууллагаар захиалж хийлгэх эсвэл хамтарч хийх	ББСБ-уудад шинэ үйлчилгээ нэвтрүүлэх замаар үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд нь судалгаа, тусламж шаардлагатай байна.	МББСБХ	2012 оны 2 дугаар улиралд
Дээрх судалгаануудын үр дүнд үндэслэн гишүүн ББСБ –ууддаа зориулж үйл ажиллагаагаа өргөжүүлэх тухай зөвлөмж боловсруулж, сургалт зохион байгуулах			МББСБХ СЗХ	2012 оны 3, 4 дүгээр улиралд
ББСБ-уудад санхүүжилт хийх боломж бүхий гадаадын санхүүгийн эх үүсвэрийн талаар судалгаа хийх	Судалгааны мэргэшсэн байгууллагаар захиалж хийлгэх эсвэл хамтарч хийх	ББСБ-уудад гадаадаас эх үүсвэр татах замаар үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд нь судалгаа, тусламж шаардлагатай байна.	МББСБХ	2013 оны 1-р улиралд
ББСБ-ууд хоорондоо нэгдэх, санхүүгийн нэгдэл үүсгэх боломж, давуу талын талаар судалгаа хийх	Судалгааны мэргэшсэн байгууллагаар захиалж хийлгэх эсвэл хамтарч хийх	ББСБ-уудад нэгдэж нийлэх замаар үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд нь судалгаа, тусламж шаардлагатай байна.	МББСБХ, СЗХ, (Судалгааны мэргэшсэн байгууллагатай хамтран)	2013 оны 2-р улиралд
Дээрх судалгаануудын үр дүнд үндэслэн гишүүн ББСБ –ууддаа зориулж үйл ажиллагаагаа өргөжүүлэх тухай зөвлөмж боловсруулж, сургалт зохион байгуулах			МББСБХ СЗХ	2012 оны 3, 4 дүгээр улиралд

Дээрх үйл ажиллагаа болон энэхүү стратеги төлөвлөгөөний 1, 3 дугаар бүлэгт заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар ББСБ-уудын санхүүгийн зах зээлд эзлэх байр суурийг 2 дахин өсгөнө.	МББСБХ СЗХ ББСБ-ууд	2013-2016
--	---------------------------	-----------

Зорилго 7. Эрх зүйн орчныг сайжруулах:

Салбарын сул талд эрх зүйн орчин хангалтгүй, тодорхой бус, зээлийн үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн таатай орчин бүрдээгүй гэж гарсан ба боломж талд хууль эрх зүйн орчин бүрдэж эхэлсэн, СЗХ, МББСБХ хамтран дүрэм журмыг сайжруулж байгаа ба дээрх сул талыг арилгах бүрэн боломжтой гэж үзсэн байна.

Зорилтууд	Хэрэгжүүлэх арга замууд	Үндэслэл, тайлбар	Хэрэгжүүлэх субъект	Хэзээ
СЗХ-ны дүрэм журам, тогтоол шийдвэрийг оновчтой, тодорхой, хэрэгжүүлэхэд ойлгомжтой болгох	СЗХ, ББСБХны хамтын ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх, Бодлогын зөвлөлийн ажлыг эрчимжүүлэх	Төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг улам сайжруулан өмнөх ололтоо бататган, сайн ажиллах, Холбоог орон тооны ажилтантай болгож ажлын чадварыг дээшлүүлэх шаардлагатай байгаа.	СЗХ, МББСБХ	2012 оноос
Иргэний хуульд нэмэлт өөрчлөлт оруулах	Иргэн зээл олгодог, санхүүгийн үйл ажиллагааг ямар нэг тусгай зөвшөөрөлгүй эрхэлдэгийг зогсоох	Зээл санхүүгийн үйл ажиллагааг иргэд ашиг олох зорилгоор ихээхэн хэмжээний мөнгөн дүнтэйгээр эргүүлж мэргэжлийн бус үйлчилгээ үзүүлдэг боллоо. Нөгөө талаар зээл олгож байгаа иргэд өөрсдөө эрсдэлд орж байна. Иргэдийн ашиг олох зорилгоор аж ахуйн хэлбэртэйгээр хүүлэх эрхийг хаах шаардлагатай байна.	СЗХ МББСБХ	2012-2016
ББСБ-ын үйл ажиллагааны тухай хуулийн шинэчлэсэн найруулгад энэхүү стратеги төлөвлөгөөнд гарсан санаануудыг оруулах			СЗХ МББСБХ	2012-2016
ШШГ ажиллагааг хөнгөвчлөх	Судалгаа хийж бодитой ажиллагаа явуулах	Жишээ нь Гүйцэтгэлийн ажиллагааг тодорхой хугацаатай болгож хуулинд оруулж өгөх. Хариуцагч шийдвэр гүйцэтгэгч 2 харилцан тохиролцож хугацааг ихээхэн удаашруулах боломжтой байдал байсаар байна.	СЗХ МББСБХ	2012-2016
Шүүхийн ажиллагааг санхүүгийн бизнесийн онцлогт уялдуулах		Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой иргэний хэргийг бусад иргэний хэрэг шиг хугацаанд шүүхийн ажиллагааг явуулдгийг болиулж өөрөөр авч үздэг болгох.	СЗХ МББСБХ	2012-2016
Эрх зүйн орчинг сайжруулах судалгаа шинжилгээ хийх			СЗХ МББСБХ	2012-2016

Зорилго 8. Төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах:

Зорилтууд	Хэрэгжүүлэх арга замууд	Үндэслэл, тайлбар	Хэрэгжүүлэх субъект	Хэзээ
Санамж бичиг байгуулах	Санамж бичгийг ойрын хугацаанд, дунд хугацаанд, урт хугацаанд чиглүүлэн тодорхой саналууд дээр үндэслэн хийх, жил бүр дүгнэж ажиллах	Төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах, ББСБ-ын үйл ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, өсөн дэвжих, цэвэр тунгалаг, шударга өрсөлдөөнтэй, хяналттай байлгахад санамж бичгийн үндсэн зорилго оршино	СЗХ МББСБХ	2012-2016
	Санамж бичигт дурдагдсан голлох зорилтууд дээр ажлын хэсэг байгуулах, тухайн ажлын хэсэг хийгдэж буй ажлуудаа тодорхой хугацаатайгаар тайлагнах	Зорилтуудыг цаг хугацаа алдалгүйгээр боломжит богино хугацаанд шийдвэрлүүлэх,		СЗХ МББСБХ
Зөвлөлийн ажиллагааг сайжруулах	СЗХ-ны дэргэдэх бичил санхүү бодлогын зөвлөлийн ажиллагааг жигдрүүлэх, үр ашгийг дээшлүүлэх	СЗХ-ны бодлого шийдвэрийг оновчтой бодитой болгох, ББСБ-д тулгамдаж буй асуудлуудыг авч хэлэлцэж шийдвэрлэх, олон улсын санхүүгийн байгууллага болон зохицуулагч байгууллагуудын стандартуудыг судлах нэвтрүүлэх, дэлхийн стандарттай нийцүүлэх гэх мэт ажлын хэсгүүдийг гарган ажиллуулж, үр дүнг сонсож, шийдвэрт хэрэглэх	СЗХ МББСБХ	2012-2016
Иргэдэд бичил санхүүгийн талаарх мэдээллийг тогтмол хүргэдэг болгох	Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн болон тухайн зах зээл дээр үйл ажиллагаа эрхлэгч мэргэжлийн оролцогчдод зориулсан мэдээ мэдээлэлийг нэгтгэн хэвлэл мэдээлэлээр тогтмол хүргэх	ББСБ-ын нэр хүндийг дээшлүүлэх, иргэдэд зөв ойлголт өгөхөд чиглэгдсэн мэдээ мэдээлэлийн чиглэлээр байнгын сурталчилгаа мэдээлэл хийх, ТВ, сонин, сэтгүүл, радио гэх мэт сувгуудаар	СЗХ, МББСБХ	2012
	МҮХАҮТ-ийн бичил санхүүгийн байгууллагуудын хөгжлийн зөвлөлтэй хамтын ажиллагааг цаашид улам гүнзгийрүүлэх	Төрийн болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хамтран сайжруулах, холбогдох хууль эрх зүйн орчныг сайжруулах, бусад танхимын зөвлөлүүдтэй хамтран ажиллах, санал солилцох,		СЗХ, МББСБХ, УИХ
Бусад төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтарч ажиллах	БСХС, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, ЖДҮГ, ОССК, Банкны бус санхүүгийн холбоод, Ажил олгогч эздийн холбоо, Хоршоологчдын холбоо, Нотариатын танхим, Өмгөөлөгчдийн холбоо, МҮЭ зэрэг нийгэмд нөлөө бүхий холбоодтой хамтарч ажиллах санамж бичиг байгуулах	ЗГ-с хэрэгжүүлж буй ажлын байрыг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх үндсэн зорилгыг ББСБ-уудаар дамжуулан хэрэгжүүлэх талаар санал солилцож ББСБ-ын хямд эх үүсвэрийг нэмэгдүүлэх, харилцан ашигтай, хамтран ажиллах	МББСБХ, бусад холбоо, төрийн бус байгууллагууд	2012-2016

	Банкны холбоотой хамтран ажиллах, ажилтануудыг чадавхжуулах, хөнгөлттэй үнээр холбогдох сургалтад хамруулах, гэрээ байгуулах	Мэргэжлийн өндөр төвшний боловсон хүчин бүрдүүлэх, ингэснээрээ ББСБ-ын үйл ажиллагаа улам чадваржиж, эрсдэл буурах, мэдлэгтэй боловсон хүчин нэмэгдэх	МББСБХ, МБ, Банкны холбоо, НБУИ болон бусад	2012-2016
ОУ-ын болон гадна дотны төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтарч ажиллах	USAID, GTZ, Milenium challenge, Дэлхийн банк, ОУ-ын валютын сан, EBRD зэрэг ОУ-ын болон төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудын санхүүгийн үйлчилгээний талаар мэдээлэл цуглуулах, төсөлд хамрагдах, хамтарч ажиллах боломжийг судлах	Гадаад харилцаа нэмэгдүүлж, ОУ-ын байгууллагуудад ББСБ-ын үүрэг ролийг ойлгуулж, цаашид хамтарч ажиллах боломжийг нээх, гишүүн ББСБ-тай хамтран хэрэгжүүлж болохуйц төсөл хөтөлбөр санаачлан хэрэгжүүлж тэдгээрийг дэмжих	МББСБХ бусад ОУ-ын байгууллагууд	2012-2016

Зорилго 9. МББСБХ-г бэхжүүлэх, хөгжүүлэх:

Зорилтууд	Хэрэгжүүлэх арга замууд	Үндэслэл, тайлбар	Хэрэгжүүлэх субъект	Хэзээ
Төрийн байгууллагын ачааллыг бууруулах үүднээс зарим эрх үүргийг Холбоонд шилжүүлэх	СЗХ-ны сургалт, сурталчилгаа, хяналт шалгалтын зарим хэсгийг Холбоо хэрэгжүүлдэг болох, үүнд чиглэсэн орон тоотой болох, Рейтинг тогтоодог болох	Төрийн зарим эрх үүргийг төрийн бус олон нийтийн байгууллага хэрэгжүүлэх санаачлагатай холбогдуулан эхний ээлжинд сургалт, олон нийтийн ажлыг Холбоо хэрэгжүүлдэг болох, цаашид хяналт шалгалтын зарим хэсгийг авсанаар төрийн байгууллагын ачааллыг бууруулах, Үйлчилгээ, ажлын байрны, ажилтаны стандартыг бий болгож хэвшүүлэх, хяналт тавих, хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулах, ББСБ-уудын үйл ажиллагаанд үнэлэлт өгч рейтинг зэрэглэл тогтоодог болох	СЗХ, МББСБХ	2012-2016
Холбоо орон тооны аппараттай болох	СЗХ-оос авдаг зохицуулалт үйлчилгээний хураамжийн 10%-ийг Холбоо өөрийн байнгын аппараттай болоход зарцуулах, цаашид 20% хүртэл нэмэгдүүлэх	СЗХ-ны зарим эрх үүргийг авч байгаатай холбогдуулан холбоо санхүүгийн дэмжлэг авах, Холбоо хүчирхэгжсэнээр СЗХ-ны ажлын ачаалал багасах, олон ББСБ-тай нэгэн зэрэг ажиллах шаардлага буурна	СЗХ, МББСБХ	2012-2016
Холбоо өөрийн байртай болох	СЗХорооны байранд байртай болох эсвэл ББСБ-ууд хувь нийлүүлэн өөрийн байртай болох,	Холбоо байнгын аппараттай болж байгаатай холбогдуулан оффис худалдаж авах, ингэснээр тэдгээрийн ажиллах нөхцөл бололцоогоор хангах, ажлыг үр дүнтэй хийхэд эерэг нөлөө үзүүлнэ	СЗХ, МББСБХ	2012-2016
Зээлийн мэдээллийн сантай болох, зээлийн эрсдлийг бууруулах	ББСБ-ууд хамтран ЗМС үйлчилгээ үзүүлэгч байгууллагыг үүсгэн байгуулах	ЗМС хуулийн дагуу цогц мэдээллийн сантай болж зээлийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдлийг бууруулах,	МББСБХ, бусад санхүүгийн байгууллагууд	2012-2013
Санхүүгийн чиглэлээр зөвлөмж өгдөг үйлчилгээг нэвтрүүлэх	Банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын талаар болон тэдгээрийн үйл ажиллагааны талаарх зөвлөмж өгөх, ном товхимол гаргах	Холбоо шинэ үйлчилгээ бий болгосноор өөрийгөө санхүүжүүлэх эх үүсвэр нэмэгдүүлэх, ингэснээр холбоо улам чадавхжих, нэр хүндтэй болох	МББСБХ	2012-2013

Гишүүнчлэлийг өргөжүүлэх, шалгуур үзүүлэлттэй болох	Гишүүн бус ББСБ-уудыг цуглуулж үйл ажиллагаагаа танилцуулах, гишүүн болсоны давуу талыг мэдрүүлэх, цаашид ил тод байдлыг эрхэмлэдэг ББСБ-ыг эгнээндээ нэгтгэх	Гишүүнчлэлийг нэмэгдүүлсэнээр Холбоо санхүүгийн чадвар сайжирна. Холбооны бие даасан байдал нэмэгдсэнээр гишүүн ББСБ-үүдийн эрх ашгийг хамгаалахад гол үүрэг гүйцэтгэнэ. Ил тод бус ББСБ-уудыг нээлттэй болгосноор Холбооны хамрах хүрээ өргөжиж нэр хүнд өснө	МББСБХ	2012
	Хамтарч нийгмийн хариуцлагатай ажлыг санаачлан хийх	Олон нийтэд эерэг бодол төрүүлэх, Холбооны нэр хүнд өсөх, Өөрсдийгөө сурталчлах	МББСБХ	2012
Холбооны нэрэмжит шагналыг өргөжүүлэх	Одоо олгож байгаа оны шилдэг эдийн засагч, теллер, нябо, менежер шалгаруулдагаас гадна Банк бус санхүүгийн салбарын тэргүүний ажилтан цол тэмдэг гаргах	Бусад холбоодын адилаар салбарынхаа тэргүүний ажилтаныг шалгаруулдаг журам гаргах. Холбоо ТББ ын нэг гол эрх үүрэг болох шагнал гардуулах эрхийн хүрээнд салбарын шилдэгийг шалгаруулах бүрэн бололцоотой гэж үзэж байна.	МББСБХ	

Гурав. Монголын банк бус санхүүгийн байгууллагын холбооны 2012 оны үйл ажиллагааны төлөвлөгөө

Зорилго 1. ББСБ-ын активын өсөлтийг хангах

Зорилго 2. Сургалт, боловсон хүчнийг чадваржуулах

Зорилго 3. Нийгмийн хариуцлагаа нэмэгдүүлэх

Зорилго 4. Зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлэх

Зорилго 5. Эрх зүйн орчныг сайжруулах

Зорилго 6. Төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах

Зорилго 7. МББСБХ-г бэхжүүлэх, хөгжүүлэх

Зорилго 1. ББСБ-ын активын өсөлтийг хангах

SWOT шинжилгээгээр ББСБ-уудын нийт активын өсөлт бага, өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаагаа явуулж байгаа, бусдын хөрөнгө дайчлах чадвар муу гэж сул талд гарсан байна. / ББСБ-уудын өөрийн хөрөнгө нь нийт Банк санхүүгийн салбарын өөрийн хөрөнгийн 21 хувийг эзлэж байгаа хэдий ч нийт активийн 2 орчим хувийг эзлэж байгаа / Иймд активын өсөлтийг хангах зайлшгүй шаардлагатай байна.

1. Зохистой харьцааны үзүүлэлтүүдийг сайжруулах

1.1 Бэлэн мөнгөний нөөцийн хувь хэмжээг 8-аас 5 хүртэл хувь болгон бууруулах

1.2 Итгэлцэл татах хэмжээг нэмэгдүүлэх

1.3 Үл хөдлөх хөрөнгийг 15-25 хувь болгон нэмэгдүүлэх

1.4 Өрийн бичиг гаргах хэмжээг нэмэгдүүлэх

2. Дотоодын төсөл хөтөлбөрт хамрагдах, зээл авах боломжийг нэмэгдүүлэх

2.1 НХХЯ ХЭДСангийн зээлийг нэмэгдүүлэх

2.2 БСХСангийн зээлийг нэмэгдүүлэх

2.3 ЖДҮГ-ын зээлийг дамжуулан зээлдүүлдэг болох

2.4 Арилжааны банкнуудад ББСБ-ын талаарх зөв ойлголтыг өгөх, хамтын ажиллагааг идэвхжүүлэх

2.5 ББСБ-уудын хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах, дэмжих

3. Гадаад харилцааг хөгжүүлэх

3.1 Гадаадын төсөл хөтөлбөрт хамрагдах, харилцаа холбоо тогтоох

3.2 Компаний засаглалыг сайжруулах, нээлттэй ил тод байдлыг уриалах, нэр хүнд бүхий аудитын компаниар аудит хийлгэх, рейтинг тогтоолгох уриалга гаргах

3.3 Олон улсын бичил санхүүгийн хурал зөвлөгөөн, уулзалтанд ББСБ-уудыг өргөнөөр оролцуулах, мэдээллээр хангах

3.4 Холбооны вэб хуудасыг сайжруулан гадаадын ижил төсөөтэй байгууллагуудтай харилцаа холбоо тогтоох, хамтран ажиллах

Зорилго 2. Сургалт, боловсон хүчнийг чадваржуулах

Боловсон хүчний сургалт дутагдалтай, Сургалтын тусгай хөтөлбөр, материаллаг баазгүй, төсөвгүй боловсон хүчнийг мэргэшүүлэх, чадваржуулах сургалтгүй, Мэдээллийн технологийн ололт амжилтыг үйл ажиллагаандаа бага нэвтрүүлсэн, Зээлийн мэдээллийн сантай харьцах харилцаа муу, боловсон хүчин болон үйл ажиллагаандаа тавих шаардлага, стандарт сул гэж SWOT шинжилгээний сул талд гарсан байна.

1. Гишүүдээс санал авсаны үндсэн дээр нэгдсэн сургалтын төлөвлөгөө боловсруулан СЗХ –той хамтран сургалтыг улирал бүр зохион байгуулах
2. Гадаад оронд болох сургалт, семинарт ББСБ-уудыг хамруулах, тэр талаарх мэдээллээр хангах
3. Гадаад харилцааг өргөжүүлэх замаар гаднаас сургалт авч эх орондоо зохион байгуулах
4. Холбооны сертификаттай сургалтын стандарт хөтөлбөр гарган хэрэгжүүлэх
5. Ихэнх ББСБ-уудыг зээлийн мэдээллийн сантай хамтран ажилладаг болгох талаар ажил зохион байгуулах
6. МБХолбоо болон бусад төрийн бус байгууллагуудтай холбогдон сургалт семинар, уулзалт зохион байгуулах
7. ББСБ-д ажиллах боловсон хүчний стандарт шаардлагыг гаргаж, баримтлах

Зорилго 3. Нийгмийн хариуцлагаа дээшлүүлэх

1. Улс орны өмнө хүлээх хариуцлагаа дээшлүүлэх

- 1.1 Нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах үүднээс бичил санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, хөгжүүлэх, дуу хоолой болох, тэдгээрийн ашиг тусыг төрд ойлгуулан, сурталчлан таниулах
- 1.2 Олон улсын бичил санхүүгийн байгууллагуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг идэвхжүүлэх, гадаадын хөрөнгө оруулагчидыг хууль эрх зүйн орчин, салбарын мэдээ, мэдээллээр хангах

1.3 Монгол улсын эдийн засгийн өндөр өсөлтийг хангахад хувь нэмэр оруулахуйц ББСБ-ын үйл ажиллагааг тогтвортой өсөлттэй байлгах, өндөр чадавхитай байлгахын төлөө ажиллах

2. Нийгэм олон нийтийн өмнө хүлээх хариуцлага

2.1 Монгол улсын засгийн газраас өрх төвтэй хөгжилд чиглэсэн бодлогод нийцүүлэн үйл ажиллагаагаа эрчимжүүлэх, хамтран ажиллах, үр дүнг нэгтгэн сурталчлах, таниулах

2.2 Нийгмийн ядуурлыг бууруулах, ажлын байр шинээр бий болгоход дорвитой хувь нэмэрээ оруулах, төсөл хөтөлбөрт хамрагдах, үр дүнг нийтэд сурталчлах, таниулах

2.3 Бичил болон жижиг, дунд үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааг дэмжих, төсөл хөтөлбөрт хамрагдах, үр дүнг нэгтгэн сурталчлах

2.4 Нийгэмрүү чиглэсэн үйл ажиллагаа, хандив тусламж, хүмүүнлэгийн үйл ажиллагааг явуулах, үйл хэргийг нийтэд сурталчлах, таниулах, нэгтгэн дүгнэх / мод тарих, хог түүх, цас цэвэрлэгээ, спорт урлагын хандивын үйл ажиллагаа гэх мэт /

3. Үйлчлүүлэгч харилцагчийн өмнө хүлээх хариуцлага

3.1 Харилцагч, үйлчлүүлэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг соёлч боловсон явуулах – / үйлчилгээний стандартыг нэвтрүүлж, хянаж, хэвшүүлнэ. /

3.2 Хэрэглэгчдэд ойртсон үйлчилгээг үзүүлж, дэлхийн жишигт нийцсэн шинэлэг технологийг нэвтрүүлэх - / Холбооноос шалгаруулдаг /

3.3 Зээлийн үйлчилгээг хялбар дөхөм болгох, төрөл бүрийн хөнгөлөлт, урамшуулал үзүүлэх ажиллагааг дэмжих

4. Хамтран ажиллагсадын өмнө хүлээх хариуцлага

4.1 Боловсон хүчний мэдлэг боловсролыг дээшлүүлж сургалт, семенарт түлхүү хамруулах

4.2 Ажилтануудын ажлын байр, ажиллах орчин нөхцлийг сайжруулах, ажлын хувцас формжуулах – / Ажлын байрны стандартыг нэвтрүүлэн хянаж хэвшүүлнэ. /

4.3 Ажилтануудын дунд эрүүл бие бялдар, эрүүл ахуйн аянг зохион байгуулах – Ууланд аялах, төрөл бүрийн спортын тэмцээн уралдаан зохион байгуулах

Зорилго 4. Зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлэх

1. ББС-ын үйл ажиллагааны тухай хуулинд заагдсан ББСБ-ын эрхэлж болох үйл ажиллагаа тус бүрээр зах зээлийн өнөөгийн байдал болон ирээдүйн хандлагын талаар нарийвчилсан судалгаа /Судалгааны мэргэшсэн байгууллагаар эсвэл хамтарч / хийх, дүгнэлт зөвлөмж гаргах
2. Хуулинд заагдаагүй хэдий ч бусад орны ББСБ-уудын эрхэлдэг үйлчилгээнүүд, манай зах зээлийн талаар судалгаа хийх, дүгнэлт зөвлөмж гаргах
3. Дээрх судалгаануудын үр дүнд үндэслэн гишүүн ББСБ-ууддаа зориулж үйл ажиллагаагаа өргөжүүлэх тухай зөвлөмж боловсруулж, сургалт зохион байгуулах

Зорилго 5. Эрх зүйн орчныг сайжруулах

Салбарын сул талд эрх зүйн орчин хангалтгүй, тодорхой бус, зээлийн үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн таатай орчин бүрдээгүй гэж гарсан ба боломж талд хууль эрх зүйн орчин

бүрдэж эхэлсэн, СЗХ, МББСБХ хамтран дүрэм журмыг сайжруулж байгаа ба дээрх сул талыг арилгах бүрэн боломжтой гэж үзсэн байна.

1. СЗХ-той байгуулах санамж бичиг болон бичил санхүүгийн бодлогын зөвлөлөөр дамжуулан СЗХ-ны дүрэм журам, тогтоол шийдвэрийг оновчтой, тодорхой, хэрэгжүүлэхэд ойлгомжтой болгох
2. Иргэнийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар иргэн зээл олгодог улмаар санхүүгийн эрсдэлд ордог асуудлыг тусгай зөвшөөрлөөр эрхэлдэг болгох ажлыг эхлүүлэх
3. ББСБ-ын үйл ажиллагааны тухай хуулийн шинэчлэсэн найруулгад энэхүү стратеги төлөвлөгөөнд гарсан санаануудыг оруулах
4. ШШГ ажиллагааг хөнгөвчлөх, хурдасгах тал дээр МБХ, СЗХ-той хамтран ажиллах
5. Шүүхийн ажиллагааг санхүүгийн бизнесийн онцлогт уялдуулах, хугацааг богиносгох талаар санхүүгийн зах зээлийн оролцогчид ялангуяа МБХ, СЗХ, Монгол банктай хамтран ажиллагаа зохион байгуулах

Зорилго 6. Төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах

1. СЗХ-той хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан идэвхтэй ажиллах
2. СЗХ-ны дэргэдэх бичил санхүү бодлогын зөвлөлийн ажиллагааг жигдрүүлэх, үр ашгийг дээшлүүлэх
3. МҮХАҮТ-ийн бичил санхүүгийн байгууллагуудын хөгжлийн зөвлөлтэй хамтын ажиллагааг цаашид улам гүнзгийрүүлэх, нягт хамтран ажиллах
4. БСХС, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, ЖДҮГ, ОССК, Банкны бус санхүүгийн холбоод, Ажил олгогч эздийн холбоо, Хоршоологчдын холбоо, Нотариатын танхим, Өмгөөлөгчдийн холбоо, МҮЭ зэрэг нийгэмд нөлөө бүхий холбоодтой хамтарч ажиллах санамж бичиг байгуулах, хамтын ажиллагааг эхлүүлэх
5. Банкны холбоотой хамтран ажиллах, эрх зүйн орчныг сайжруулах болон боловсон хүчин ажилтануудыг чадавхжуулах, сургалтад хамруулах, нийгэмрүү чиглэсэн ажиллагаа зэрэгт хамтран ажиллах
6. USAID, GTZ, Milenium challenge, Дэлхийн банк, ОУ-ын валютын сан, EBRD зэрэг ОУ-ын болон төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудын санхүүгийн үйлчилгээний талаар мэдээлэл цуглуулах, төсөлд хамрагдах, хамтарч ажиллах боломжийг судлах

Зорилго 7. МББСБХ-г бэхжүүлэх, хөгжүүлэх

1. Холбоо гүйцэтгэх ажлын орон тооны ажилтантай болох хэвийн үйл ажиллагааг явуулах хэмжээний төсөвтэй болох
2. Төрийн байгууллагын хэрэгжүүлж чадахгүй байгаа зарим чиг үүргийг холбоонд авах / сургалт, суртал ухуулга, таниулга, үйлчилгээ, ажлын байр, боловсон хүчнийн стандартуудыг хэвшүүлэх /
3. Холбоо өөрийн байртай болох асуудлыг ярьж хөөцөлдөж эхлэх
4. Гишүүн бус ББСБ-уудыг цуглуулж холбооны үйл ажиллагаагаа танилцуулах, гишүүн болсоны давуу талыг мэдрүүлж гишүүнчлэлийг нэмэгдүүлэх, цаашид ил тод байдлыг эрхэмлэдэг ББСБ-ыг эгнээндээ нэгтгэх улмаар гишүүнчлэлийн шалгуур үзүүлэлтийг гаргах

5. Холбооны нэрэмжит шагналыг өргөжүүлэх / Одоо олгож байгаа оны шилдэг эдийн засагч, теллер, нябо, менежер шалгаруулдагаас гадна Банк бус санхүүгийн салбарын тэргүүний ажилтан цол тэмдэг гаргах /
6. ББСБ-уудад зэрэглэл тогтоох ажлын эхлэлийг тавих / тоон болон чанарын үзүүлэлтээр ББСБ-уудыг дүгнэдэг болох, нээлттэй ил тод болгох /

СЗХ-той хамтран Цэцээ гүний орой руу явган аялал гишүүдийнхээ дунд зохион байгуулна.
Шинэ жилийн нэгдсэн арга хэмжээг 4 дахь жилдээ амжилттай зохион байгуулж, оролцогсдын тоог улам нэмэгдүүлэх
Гишүүддээ тэмдэглэлт баяр, ойн арга хэмжээ, баяр наадмын мэндийг байнга дэвшүүлдэг болох
Холбооны зүгээс уламжлалт номинациар шилдэгүүдээ шалгаруулахын зэрэгцээ СЗХ, МЗХ-ны шагналд шилдэгүүдээ тодорхойлно.

МББСБХОЛБОО

СТРАТЕГИ БОДЛОГО, ХӨГЖИЛ ХАРИУЦСАН ХОРОО

-- ○○○○ --